



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2020/2/СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл



Агуулга

Аудитын гэрчилгээ.....	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	7
Менежментийн захидал	8
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	9
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11





2.1. Оршил

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Н.Мөнхгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/60 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эрхэм зорилго нь “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, зорилтод бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх замаар нийгмийн хамгааллыг сайжруулах”-д оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ
- Ажилд зуучлах
- Хөдөлмөрт бэлтгэх
- Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах
- Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих
- Ажил олгогчийг дэмжих
- Нийтийг хамарсан ажил зохион байгуулах
- Ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Explorer программ хангамж ашигладаг байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн



үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,113,346.0 мянган төгрөгөөс тооцон 22,266.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 17,323.2 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл буурсантай холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 483,727.4 мянган төгрөгөөр буюу 35,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0	
Авлага	1370183.5	1853910.9	483727.4	35.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0	
Бараа материал	0.0	0.0	0.0	
Үндсэн хөрөнгө	0.0	0.0	0.0	
Нийт хөрөнгө	1370183.5	1853910.9	483727.4	35.3
Өр төлбөр	0.0	0.0	0.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1370183.5	1853910.9	483727.4	35.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1370183.5	1853910.9	483727.4	35.3

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 809,000.0 мянган төгрөгийн зээл олгосон, зээлийн эргэн төлөлтөөр 325,920.9 мянган төгрөг орж ирсэн зэрэгээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Үндсэн үйл ажиллагааны орлого хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн нөхөн төлбөрөөр 10,387.5 мянган төгрөг, хөтөлбөр төсвийн зээлийн эргэн төлөлт 325,920.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,346,386.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Нийт зардлын 1,346,386.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 6 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 480,459.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын талаар

1.1. Илрүүлэлт: Нийт 1,853,910.9 мянган төгрөгийн авлагын 26 хувь буюу 480,459.7 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага байна.

1.2. Эрсдэл: Найдваргүй авлага үүсэх.

1.3. Өгсөн зөвлөмж: хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1370183550.00	1853910950.00
33	АВЛАГА	1370183550.00	1853910950.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2525000.00	3173300.00
33400	Зээлийн хүүгийн авлага	1332752700.00	1816476800.00
335	Бусад авлага	34905850.00	34260850.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	34905850.00	34260850.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1370183550.00	1853910950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1370183550.00	1853910950.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1370183550.00	1853910950.00
512	Хуримтлагдсан үр дүн	1370183550.00	1853910950.00
51210	Өмнөх үеийн үр дүн	935341600.00	1370183550.00
51220	Тайлант үеийн үр дүн	434841950.00	483727400.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1370183550.00	1853910950.00

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1548188000.00	1349887500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14688000.00	10387500.00
120	Нийтлэг татварын бус орлого	14688000.00	10387500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14688000.00	10387500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14688000.00	10387500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1533500000.00	1339500000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1533500000.00	1339500000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1533500000.00	1339500000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1113346050.00	866160100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1113346050.00	866160100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	4000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1109346050.00	862160100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	831242857.00	528869284.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	831242857.00	528869284.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	257143.00	10387500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	257143.00	10387500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14688000.00	155716.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14688000.00	155716.00



2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	263158050.00	322747600.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	263158050.00	322747600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>434841950.00</u>	<u>483727400.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>434841950.00</u>	<u>483727400.00</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1813871050.00</u>	<u>1678333400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>280371050.00</u>	<u>336308400.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	280371050.00	336308400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	280371050.00	336308400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	265683050.00	325920900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14688000.00	10387500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1533500000.00</u>	<u>1342025000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1533500000.00	1342025000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1533500000.00	1339500000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	2525000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1813871050.00</u>	<u>1678333400.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1813871050.00</u>	<u>1678333400.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>4000000.00</u>	<u>4000000.00</u>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>1809871050.00</u>	<u>1674333400.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	1529242857.00	1337869284.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1529242857.00	1337869284.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2782143.00	10387500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2782143.00	10387500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14688000.00	3329016.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14688000.00	3329016.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	263158050.00	322747600.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	263158050.00	322747600.00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,370,183,550.00	0.00	1,370,183,550.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,370,183,550.00	0.00	1,370,183,550.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,370,183,550.00	0.00	1,370,183,550.00
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,370,183,550.00	0.00	1,370,183,550.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,370,183,550.00	0.00	1,370,183,550.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	483,727,400.00	0.00	483,727,400.00
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,853,910,950.00	0.00	1,853,910,950.00

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1533242857.00	1341869284.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1533242857.00	1341869284.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	4000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1529242857.00	1337869284.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1529242857.00	1337869284.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1529242857.00	1337869284.00

